



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

2024 оны эхний хагас жилийн
ТАНИЛЦУУЛГА (урьдчилсан гүйцэтгэл)



УЛААНБААТАР ХОТ
2024 ОН



ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот
2024 оны 8 дугаар сарын 16

АГУУЛГА

НЭГ. ДНБ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АРГААР.....	4
ХОЁР. ДНБ, ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААР.....	10
ГУРАВ. ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО, ҮНДЭСНИЙ НИЙТ ЭЗЭМШЛИЙН ОРЛОГО	13

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. ДНБ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АРГААР, ОНЫ ҮНЭЭР	4
ХҮСНЭГТ 2. ДНБ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АРГААР, 2015 ОНЫ ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮНЭЭР	4
ХҮСНЭГТ 3. ДНБ-ИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТАД САЛБАРУУДЫН ОРОЛЦОО, НЭГЖ ХУВИАР	6
ХҮСНЭГТ 4. УУЛ УУРХАЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ОЛБОРЛОЛТ, ЭКСПОРТ	7
ХҮСНЭГТ 5. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАТВАР, ТӨРЛӨӨР	9
ХҮСНЭГТ 6. ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААРХ ДНБ, ОНЫ ҮНЭЭР	10
ХҮСНЭГТ 7. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН НИЙТ ХУРИМТЛАЛ, ХӨРӨНГИЙН ТӨРЛӨӨР, ОНЫ ҮНЭЭР	11
ХҮСНЭГТ 8. ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААРХ ДНБ, 2015 ОНЫ ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮНЭЭР	12
ХҮСНЭГТ 9. ДНБ-ИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТАД БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГИЙН ОРОЛЦОО, НЭГЖ ХУВИАР	12
ХҮСНЭГТ 10. ДНБ, УНО, ҮНЭО, ОНЫ ҮНЭЭР	13
ХҮСНЭГТ 11. ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ ХАГАС ЖИЛД.....	14

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. ДНБ-ИЙ САЛБАРЫН БҮТЭЦ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР	4
ЗУРАГ 2. ДНБ-ИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТ, УУЛ УУРХАЙ, УУЛ УУРХАЙН БУС САЛБАРЫН ОРОЛЦОО	5
ЗУРАГ 3. ДНБ (УЛИРЛЫН НӨЛӨӨЛЛИЙГ АРИЛГАСАН)-ИЙ ЦЭВЭР ӨСӨЛТ, БУУРАЛТ, ХУВИАР (2015 ОНЫ ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮНЭЭР, ӨМНӨХ УЛИРЛААС).....	5
ЗУРАГ 4. БОЙЖУУЛСАН ТӨЛ, ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ	6
ЗУРАГ 5. ҮЙЛДВЭРЛЭЛ, БАРИЛГЫН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ӨСӨЛТ, БУУРАЛТ, ХУВИАР.....	7
ЗУРАГ 6. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ӨСӨЛТ, БУУРАЛТ, ХУВИАР	8
ЗУРАГ 7. ДОТООД ХУДАЛДААНЫ БОРЛУУЛАЛТ, БАРААНЫ ИМПОРТЫН ХЭМЖЭЭ	8
ЗУРАГ 8. ТЭЭСЭН АЧАА, САЯ.....	9
ЗУРАГ 9. ЗОРЧИГЧИД, САЯ ХҮН	9
ЗУРАГ 10. ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ БҮТЭЦ, ХУВИАР	10
ЗУРАГ 11. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭКСПОРТ, ИМПОРТ, ИХ НАЯД ТӨГРӨГӨӨР	11
ЗУРАГ 12. АНХДАГЧ ОРЛОГО, УНО, ДНБ-ИЙ ХАРЬЦАА.....	13

Тайлбар:



* Урьдчилсан гүйцэтгэл



ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН (ДНБ)

МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСАГ
2024 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛД

Монгол Улсын
эдийн засаг 2024 оны
эхний хагас жилд



ХӨДӨӨ АЖ АХУЙ



УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ



АЖ ҮЙЛДВЭР², БАРИЛГА



ҮЙЛЧИЛГЭЭ



БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЦЭВЭР ТАТВАР



Өсөлт, бууралт
Оролцоо, нэгж хувиар

ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААРХ ДНБ-ИЙ БҮТЭЦ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР



² Уул уурхай, олборлолтын салбар ороогүй

Монгол Улсын эдийн засаг 2024 оны эхний хагас жилд 5.6 хувиар өслөө.

Нэг. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар


Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ, оны үнээр 2024 оны эхний хагас жилд 37.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.4 (20.8%) их наяд төгрөгөөр өслөө. ДНБ нэмэгдэхэд өмнөх оны мөн үеэс уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 1.8 (20.0%) их наяд төгрөгөөр, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 3.8 (31.2%) их наяд төгрөгөөр өссөн нь нөлөөлөв.

ХҮСНЭГТ 1. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр

Үзүүлэлт	2022	2023	2024*	Өөрчлөлт	
	I-VI	I-VI	I-VI	дүн	хувь
ДНБ	23 352.6	30 979.6	37 419.7	6 440.1	20.8
Хөдөө аж ахуй	3 525.7	3 650.6	3 401.0	- 249.6	-6.8
Уул уурхай, олборлолт	5 370.6	9 232.3	11 078.0	1 845.8	20.0
Үйлдвэрлэл, барилга	2 224.7	2 812.0	3 102.5	290.5	10.3
Үйлчилгээ	9 507.9	12 192.4	16 001.1	3 808.7	31.2
Бүтээгдэхүүний цэвэр татвар	2 723.7	3 092.3	3 837.0	744.7	24.1

ДНБ-ий салбарын бүтцийг авч үзвэл, 2024 оны эхний хагас жилд үйлчилгээний салбар 42.8 хувь, уул уурхай, олборлолт 29.6 хувь, хөдөө аж ахуй 9.1 хувь, үйлдвэрлэл, барилга 8.3 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 10.3 хувийг тус тус эзэлж байна (Зураг 1).

ЗУРАГ 1. ДНБ-ИЙ САЛБАРЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар



ДНБ-ий салбарын бүтцийг өмнөх оныхтой харьцуулбал, үйлчилгээний салбарынх 3.4 нэгж хувиар, бүтээгдэхүүний цэвэр татвар 0.3 нэгж хувиар нэмэгдэж, уул уурхай, олборлолтын салбарынх 0.2 нэгж хувь, хөдөө аж ахуйн салбарынх 2.7 нэгж хувь, үйлдвэрлэл, барилгынх 0.8 нэгж хувиар тус тус буурсан байна.


ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, 2024 оны эхний хагас жилд 14.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 758.3 (5.6%) тэрбум төгрөгөөр өсөхөд уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 249.7 (15.4%) тэрбум төгрөгөөр, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 604.3 (9.3%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

ХҮСНЭГТ 2. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр

Үзүүлэлт	2022	2023	2024*	Өөрчлөлт	
	I-VI	I-VI	I-VI	дүн	хувь
ДНБ	12 807.9	13 660.8	14 419.1	758.3	5.6
Хөдөө аж ахуй	2 186.1	1 969.3	1 443.1	-526.2	-26.7
Уул уурхай, олборлолт	1 117.8	1 620.2	1 869.9	249.7	15.4
Үйлдвэрлэл, барилга	1 399.5	1 436.8	1 549.8	113.0	7.9
Үйлчилгээ	6 036.4	6 517.1	7 121.4	604.3	9.3
Бүтээгдэхүүний цэвэр татвар	2 068.0	2 117.4	2 434.8	317.5	15.0

ЗУРАГ 2. ДНБ-ИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТ, уул уурхай, уул уурхайн бус салбарын оролцоо


ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, 2024 оны эхний хагас жилд 5.6 хувиар өсөхөд уул уурхайн салбарын нэмэгдэл өртгийн оролцоо 1.8 нэгж хувь, уул уурхайн бус салбарынх 1.4 нэгж хувь, бүтээгдэхүүний цэвэр татварынх 2.3 нэгж хувь байна (Зураг 2).



Улирлын нөлөөллийг арилгасан ДНБ

Улирлын нөлөөллийг арилган тооцсон ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 2024 оны 2 дугаар улиралд өмнөх улирлаас 1.5 хувиар өслөө (Зураг 3).

ЗУРАГ 3. ДНБ (УЛИРЛЫН НӨЛӨӨЛЛИЙГ АРИЛГАСАН)-ИЙ ЦЭВЭР ӨСӨЛТ, БУУРАЛТ, хувиар (2015 оны зэрэгцүүлэх үнээр, өмнөх улирлаас)



Эдийн засагт голлох салбаруудын үйлдвэрлэл

ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, 2024 оны эхний хагас жилд 5.6 хувиар өссөний 1.8 нэгж хувь нь уул уурхай, олборлолтын салбарт, 4.4 нэгж хувь нь үйлчилгээний салбарт, 0.8 нэгж хувь нь үйлдвэрлэл, барилгын салбарт, -3.9 нэгж хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 2.3 нэгж хувь нь бүтээгдэхүүний цэвэр татварт ногдож байна.

ХҮСНЭГТ 3. ДНБ-ИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТАД САЛБАРУУДЫН ОРОЛЦОО


Салбар	2022				2023				2024*	
	I-III	I-VI	I-IX	I-XII	I-III	I-VI	I-IX	I-XII	I-III	I-VI
	нэгж хувь									
ДНБ-ий өсөлт, бууралт %	-3.8	2.0	3.8	5.0	8.0	6.7	7.2	7.4	7.9	5.6
Хөдөө аж ахуй	0.5	1.8	1.6	1.7	-0.2	-1.7	-1.6	-1.3	-1.0	-3.9
Уул уурхай, олборлолт	-6.4	-4.0	-2.7	-2.1	5.1	3.9	3.3	2.6	1.9	1.8
Үйлдвэрлэл, барилга	-0.9	-0.1	0.3	0.8	-0.3	0.3	0.5	0.7	0.9	0.8
Боловсруулах	-0.7	-0.1	0.1	0.5	-0.5	0.1	0.3	0.4	0.3	0.4
Цахилгаан, хий, уур, усан хангамж	0.2	0.2	0.1	0.1	0.2	0.1	0.1	0.1	0.3	0.2
Барилга	-0.4	-0.1	0.1	0.2	0.0	0.0	0.1	0.1	0.2	0.3
Үйлчилгээ	1.4	2.6	2.9	3.2	4.1	3.8	4.4	4.7	4.0	4.4
Бөөний, жижиглэн худалдаа	0.8	1.4	1.3	1.1	1.1	0.8	0.8	0.8	0.7	0.7
Тээвэр, агуулах	-1.3	-0.6	0.1	0.4	2.2	1.9	2.2	1.8	1.3	1.0
Мэдээлэл, холбоо	0.4	0.4	0.2	0.2	0.2	0.4	0.5	0.5	0.9	0.6
Үйлчилгээний бусад	1.5	1.5	1.2	1.6	0.6	0.7	1.0	1.7	1.2	2.1
Бүтээгдэхүүний цэвэр татвар	1.6	1.7	1.7	1.4	-0.7	0.4	0.6	0.8	2.1	2.3

Хөдөө аж ахуйн салбар

Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2024 оны эхний хагас жилд 1.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 526.2 (26.7%) тэрбум төгрөгөөр буурсан нь ДНБ-д 3.9 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлсэн байна.

Улсын хэмжээнд 2023 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 30.0 сая хээлтэгч малын 17.0 (56.5%) сая нь 2024 оны эхний хагас жилд төллөсөн байна. Гарсан төлийн 90.9 хувь буюу 15.4 сая төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 2.6 (14.5%) саяар буурсан байна. Том малын зүй бус хорогдол 2024 оны эхний хагас жилд улсын хэмжээнд 8.1 сая болж, өмнөх оны мөн үеэс 4.2 (2.1 дахин) саяар өссөн байна (Зураг 4). Хорогдсон том малын 85.7 хувийг хонь, ямаа эзэлж байна.

ЗУРАГ 4. БОЙЖУУЛСАН ТӨЛ, ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ



Уул уурхай, олборлолтын салбар

Уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, 2024 оны эхний хагас жилд 1.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 249.7 (15.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. ДНБ-ий 5.6 хувийн өсөлтийн 1.8 нэгж хувь нь уг салбарт ногдож байна.

Уул уурхай, олборлолтын салбарын ихэнх бүтээгдэхүүний экспорт өмнөх оны мөн үеэс өссөн байна (Хүснэгт 4). Тухайлбал, 2024 оны эхний хагас жилд нүүрсний экспорт 37.6 хувь, төмрийн хүдэр, баяжмал 34.1 хувь, хайлуур жонш, баяжмал 33.8 хувь, зэсийн баяжмал 2.7 хувиар тус тус өсжээ. Харин цайрын хүдэр, баяжмалын экспорт өмнөх оны мөн үеэс 38.0 хувь, алт 6.5 хувь, газрын тос 13.0 хувь, молибдений баяжмал 4.2 хувиар тус тус буурсан байна.


ХҮСНЭГТ 4. УУЛ УУРХАЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ ОЛБОРЛОЛТ, ЭКСПОРТ

Уул уурхайн бүтээгдэхүүн	2022 I-VI		2023 I-VI		2024* I-VI		Өөрчлөлт			
	Олборлолт	Экспорт	Олборлолт	Экспорт	Олборлолт	Экспорт	Олборлолт	Экспорт	Олборлолт	Экспорт
	мянган тонн						дүн		хувь	
Нүүрс, сая т	10.4	8.1	35.1	29.5	47.6	40.6	12.6	11.1	35.9	37.6
Газрын тос, сая баррель	0.1	0.1	2.5	2.4	2.1	2.1	- 0.3	- 0.3	-13.5	-13.0
Молибдений баяжмал	2.6	2.8	3.0	3.4	3.0	3.2	0.0	- 0.1	-0.6	-4.2
Алт, т	7.6	8.6	6.5	5.4	5.3	5.0	- 1.1	- 0.4	-17.7	-6.5
Төмрийн хүдэр, баяжмал, сая т	5.4	1.7	3.1	2.7	4.6	3.6	1.5	0.9	47.2	34.1
Зэсийн баяжмал	553.6	747.8	704.7	764.3	734.5	785.2	29.8	20.9	4.2	2.7
Хайлуур жонш, баяжмал	50.2	167.4	102.5	436.4	186.4	583.8	83.9	147.4	81.9	33.8
Цайрын хүдэр, баяжмал	35.7	73.4	176.6	100.1	252.0	62.1	75.4	- 38.0	42.7	-38.0

Үйлдвэрлэл, барилга

Үйлдвэрлэл, барилгын салбарын нэмэгдэл өртөг, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, 2024 оны эхний хагас жилд 1.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 113.0 (7.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна. ДНБ-ий 5.6 хувийн өсөлтийн 0.8 нэгж хувь нь уг салбарт ногдож байна.

ЗУРАГ 5. ҮЙЛДВЭРЛЭЛ, БАРИЛГЫН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ӨСӨЛТ, БУУРАЛТ, ХУВИАР



Үйлдвэрлэл, барилгын салбарын нэмэгдэл өртөг (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2024 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар өсөхөд боловсруулах салбар 6.3 хувь, барилгын салбар 19.5 хувиар өссөн нь голлон нөлөөллөө.

Барилга угсралт, их засварын ажил 3.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 24.2 хувиар өссөн.

Үйлчилгээний салбар

Үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, 2024 оны эхний хагас жилд 7.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 604.3 (9.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна. ДНБ-ий 5.6 хувийн өсөлтийн 4.4 нэгж хувь нь уг салбарт ногдож байна

ЗУРАГ 6. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ӨСӨЛТ, БУУРАЛТ, ХУВИАР



Үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2024 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 9.3 хувиар өсөж, өмнөх оноос 1.3 нэгж хувиар нэмэгдсэн байна. Уг өсөлтөд үйлчилгээний бусад салбарын нэмэгдэл өртөг 7.1 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Бөөний болон жижиглэн худалдааны салбар

Бөөний болон жижиглэн худалдаа (дотоод худалдаа)-ны нийт борлуулалт 2024 оны эхний хагас жилд 31.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.4 (16.7%) их наяд төгрөгөөр өслөө.

Барааны импортын хэмжээ 2024 оны эхний хагас жилд 5.4 тэрбум америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 1.1 (25.9%) тэрбум америк доллароор өссөн байна.

ЗУРАГ 7. ДОТООД ХУДАЛДААНЫ БОРЛУУЛАЛТ, БАРААНЫ ИМПОРТЫН ХЭМЖЭЭ




Тээвэр, мэдээлэл холбооны салбар


Бүх төрлийн тээврийн орлого 2024 оны эхний хагас жилд 3.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 693.6 (24.8%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2024 оны эхний хагас жилд 55.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 6.4 (12.9%) сая тонноор өсжээ. Тээврийн төрлөөр авч үзвэл, авто тээврээр тээсэн ачаа 9.9 (33.9%) сая тонноор, төмөр замаар тээсэн ачаа 0.5 (3.3%) сая тонноор тус тус өссөн байна.

ЗУРАГ 8. ТЭЭСЭН АЧАА, сая т



ЗУРАГ 9. ЗОРЧИГЧИД, сая хүн



Харин мэдээлэл, харилцаа холбооны салбарын орлого 2024 оны эхний хагас жилд 1.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 183.6 (18.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Үйлчилгээний бусад салбар

Үйлчилгээний бусад салбарт зочид буудал, зоогийн газрын салбар, санхүү, даатгалын салбар, үл хөдлөх хөрөнгө, мэргэжлийн, шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагаа; төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа; боловсрол; нийгмийн халамж; урлаг, үзвэр, тоглоом наадам зэрэг салбар хамрагдана. Уг салбарын нэмэгдэл өртгийн дийлэнх хувийг төсөвт байгууллага эзэлдэг.

Үйлчилгээний бусад салбарын нэмэгдэл өртөг оны үнээр 2024 оны эхний хагас жилд 10.1 их наяд төгрөг болж, ДНБ-ий 27.0 хувийг бүрдүүлсэн байна. Үйлчилгээний бусад салбарын нэмэгдэл өртөг (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2024 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар өссөн байна.

Бүтээгдэхүүний татвар, татаас

Бүтээгдэхүүний цэвэр татвар буюу бүтээгдэхүүний татвар, татаасын зөрүү, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, 2024 оны эхний хагас жилд 2.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 15.0 хувиар өссөн байна.

Бүтээгдэхүүний татвар оны үнээр 2024 оны эхний хагас жилд 4.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 26.6 хувиар өсөхөд нэмэгдсэн өртгийн албан татвар 27.3 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 5. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАТВАР, төрлөөр

	2022 I-VI	2023 I-VI	2024* I-VI	Өөрчлөлт	
	тэрбум төгрөг			дүн	хувь
Бүтээгдэхүүний татвар	2 862.7	3 252.0	4 117.5	865.5	26.6
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1 804.7	2 182.2	2 776.8	594.6	27.3
Онцгой татвар	466.0	374.0	515.4	141.4	37.8
Тусгай зориулалтын орлого	9.4	10.2	12.5	2.3	22.6
Гадаад худалдааны татвар	582.7	685.6	812.8	127.1	18.5

Хоёр. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, оны үнээр 2024 оны эхний хагас жилд 38.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.5 (24.5%) их наяд төгрөгөөр өслөө.

ХҮСНЭГТ 6. ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААРХ ДНБ, оны үнээр

Бүрэлдэхүүн	2022	2023	2024*	Өөрчлөлт	
	I-VI	I-VI	I-VI	дүн	хувь
	тэрбум төгрөг				
ДНБ	22 746.9	30 540.4	38 022.4	7 482.0	24.5
Эцсийн хэрэглээ	16 419.0	18 750.1	26 057.0	7 306.9	39.0
Өрхийн аж ахуй ¹	13 475.6	14 695.1	18 988.6	4 293.4	29.2
Төрийн байгууллагын хэрэглээ	2 943.3	4 055.0	7 068.5	3 013.5	74.3
Хөрөнгийн нийт хуримтлал	9 487.7	8 062.2	9 985.2	1 923.0	23.9
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	5 659.1	7 222.7	7 755.7	533.0	7.4
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт ²	3 828.6	832.8	2 229.5	1 390.0	2.7*
Бараа, үйлчилгээний цэвэр экспорт	- 3 159.8	3 728.1	1 980.2	- 1 748.0	-
Бараа, үйлчилгээний экспорт	12 422.0	25 699.8	27 317.9	1 618.1	6.3
Бараа, үйлчилгээний импорт (-)	15 581.7	21 971.7	25 337.8	3 366.1	15.3

¹ - Өрхийн хэрэглээний дүнд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.

² - Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дүнд үнэт зүйлсийн хуримтлал, статистик зөрүү орсон.

*дахин их

Эцсийн хэрэглээ


Эцсийн хэрэглээ оны үнээр, 2024 оны эхний хагас жилд 26.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.3 их наяд төгрөг буюу 39.0 хувиар өссөн байна.

Нийт эцсийн хэрэглээний 72.9 хувийг өрхийн аж ахуйн хэрэглээ, 27.1 хувийг төрийн байгууллагын хэрэглээ бүрдүүлж байна (Хүснэгт 6).

Өрхийн хэрэглээний 39.8 хувийг хүнсний хэрэглээ, 60.2 хувийг хүнсний бус хэрэглээ, үйлчилгээ эзэлж байна (Зураг 10).

Өрхийн хүнсний хэрэглээ өмнөх оны мөн үеэс 1.5 (24.9%) их наяд төгрөгөөр, хүнсний бус бараа, үйлчилгээний хэрэглээ өмнөх оны мөн үеэс 2.8 (32.4%) их наяд төгрөгөөр тус тус өслөө.

ЗУРАГ 10. ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ БҮТЭЦ, хувиар



Хөрөнгийн нийт хуримтлал

Хөрөнгийн нийт хуримтлал, оны үнээр, 2024 оны эхний хагас жилд 10.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (23.9%) их наяд төгрөгөөр өссөн байна. Хөрөнгийн нийт хуримтлалын 77.7 хувийг үндсэн хөрөнгийн нийт хуримтлал бүрдүүлж байна.

Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал өмнөх оны мөн үеэс 533.0 (7.4%) тэрбум төгрөгөөр, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт 1.4 (2.7 дахин) их наяд төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн нийт хуримтлалын барилга байгууламжийн хөрөнгө 773.4 (24.5%) тэрбум төгрөгөөр, машин, тоног төхөөрөмжийнх 1.5 (38.3%) их наяд төгрөгөөр нэмэгджээ.


ХҮСНЭГТ 7. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН НИЙТ ХУРИМТЛАЛ, хөрөнгийн төрлөөр, оны үнээр

Үзүүлэлт	2022	2023	2024*	Өөрчлөлт	
	I-VI	I-VI	I-VI	дүн	хувь
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	6 263.2	7 222.7	7 755.7	533.0	7.4
Барилга байгууламж	6 157.4	7 093.6	7 455.2	361.5	5.1
Машин тоног төхөөрөмж	2 171.2	3 151.8	3 925.1	773.4	24.5
Өсөж үрждэг хөрөнгө	3 723.1	3 933.7	5 441.6	1 507.9	38.3
Бусад	263.1	8.2	-1 911.6	-1 919.8	-

Бараа, үйлчилгээний экспорт, импорт

Бараа, үйлчилгээний экспорт, оны үнээр, 2024 оны эхний хагас жилд 27.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.6 (6.3%) их наяд төгрөгөөр, импорт 25.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.4 (15.3%) их наяд төгрөгөөр өслөө.

ЗУРАГ 11. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭКСПОРТ, ИМПОРТ, их наяд төгрөгөөр



ДНБ (эцсийн ашиглалтын аргаар тооцсон, 2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2024 оны эхний хагас жилд 14.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 766.2 (5.7%) тэрбум төгрөгөөр өслөө.

ХҮСНЭГТ 8. ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААРХ ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр

Бүрэлдэхүүн	2022	2023	2024*	Өөрчлөлт	
	I-VI	I-VI	I-VI	дүн	хувь
ДНБ	12 542.3	13 328.5	14 094.7	766.2	5.7
Эцсийн хэрэглээ	11 211.7	12 182.7	15 042.3	2 859.6	23.5
Өрхийн аж ахуй ¹	8 943.1	9 527.9	11 141.5	1 613.6	16.9
Төрийн байгууллагын хэрэглээ	2 268.7	2 654.8	3 900.8	1 246.0	46.9
Хөрөнгийн нийт хуримтлал	6 581.5	4 717.6	5 548.8	831.3	17.6
Үндсэн хөрөнгийн нийт					
Хуримтлал	3 896.0	4 166.2	4 193.5	27.3	0.7
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт ²	2 685.6	551.4	1 355.3	803.9	145.8
Бараа, үйлчилгээний цэвэр экспорт	-5 251.0	-3 571.7	-6 496.4	-2 924.7	81.9
Бараа, үйлчилгээний экспорт	5 005.0	9 657.4	9 460.2	- 197.3	- 2.0
Бараа, үйлчилгээний импорт (-)	10 256.0	13 229.1	15 956.5	2 727.4	20.6

¹ - Өрхийн хэрэглээний дүнд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.

² - Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дүнд үнэт зүйлсийн хуримтлал, статистик зөрүү орсон.

Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ 2022 онд эхний хагас жилд 0.2 хувиар буурч байсан бол 2023 оны эхний хагас жилд 6.3 хувиар, 2024 оны эхний хагас жилд 5.7 хувиар өслөө. ДНБ-ий 2023 оны эхний хагас жилийн 6.3 хувийн өсөлтөд эцсийн хэрэглээ 7.7 нэгж хувийн эерэг оролцоотой байсан бол 2024 оны эхний хагас жилийн 5.7 хувийн өсөлтөд 21.5 нэгж хувийн эерэг оролцоотой болж өссөн байна (Хүснэгт 9).

ХҮСНЭГТ 9. ДНБ-ИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТАД БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГИЙН ОРОЛЦОО

Бүрэлдэхүүн	2022				2023				2024*	
	I-III	I-VI	I-IX	I-XII	I-III	I-VI	I-IX	I-XII	I-III	I-VI
	нэгж хувь									
ДНБ-ий өсөлт, бууралт %	-2.5	-0.2	2.6	5.0	7.9	6.3	7.2	7.2	8.0	5.7
Эцсийн хэрэглээ	7.4	6.1	6.0	6.5	4.1	7.7	9.7	7.0	22.0	21.5
Өрхийн хэрэглээ ¹	6.5	5.0	5.1	5.1	2.0	4.7	6.3	6.3	12.7	12.1
Төрийн байгууллагын хэрэглээ	0.9	1.1	0.9	1.4	2.0	3.1	3.3	0.7	9.3	9.3
Хөрөнгийн нийт хуримтлал	10.2	14.3	4.1	4.9	-6.6	-14.9	-11.2	-1.6	10.5	6.2
Үндсэн хөрөнгийн хуримтлал	0.5	3.7	4.1	3.9	4.0	2.2	2.2	1.7	6.1	0.2
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт ²	9.7	10.5	0.0	1.0	-10.6	-17.0	-13.4	-3.3	4.4	6.0
Бараа, үйлчилгээний цэвэр экспорт	-20.0	-20.5	-7.5	-6.4	10.4	13.4	8.8	1.8	-24.5	-21.9
Бараа, үйлчилгээний экспорт	-15.7	-6.6	10.9	13.9	44.4	37.1	27.7	18.0	-7.2	-1.5
Бараа, үйлчилгээний импорт(-)	4.4	13.9	18.4	20.3	34.0	23.7	19.0	16.2	17.3	20.5

Гурав. Үндэсний нийт орлого, Үндэсний нийт эзэмшлийн орлого

Үндэсний нийт орлого (ҮНО) нь тухайн улсын эдийн засгийн харьяатуудын шинээр бий болгосон нэмэгдсэн өртөг бөгөөд ҮНО-ыг тооцохдоо ДНБ-ий гүйцэтгэл дээр харьяат болон харьяат бусын хооронд хийгдсэн анхдагч цэвэр орлогын хэмжээг нэмнэ. Анхдагч орлогод харьяат бус ажиллагчдад төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого болон хөрөнгө оруулалтын орлого буюу харьяат, харьяат бусын хооронд харилцан шилжүүлсэн ногдол ашиг, хүүгийн орлого орно.


Үндэсний нийт эзэмшлийн орлого (ҮНЭО) нь зарцуулах боломжтой орлогыг илэрхийлнэ. ҮНЭО-ыг ҮНО болон харьяат, харьяат бусын хооронд хийгдсэн хоёрдогч орлого буюу цэвэр шилжүүлгийн нийлбэрээр тооцно. Шилжүүлэг гэдэг нь эдийн засгийн нэг сектор нөгөө сектортоо ямар нэг хариу төлбөр авахгүйгээр өгч байгаа бараа, үйлчилгээ, санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгө юм. Урсгал шилжүүлэг нь урсгал татвар, нийгмийн даатгалын шимтгэл, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, бусад урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Гадаад эдийн засгаас хүлээн авсан цэвэр орлого 2024 оны эхний хагас жилд (-3.8) их наяд төгрөг, хоёрдогч орлого буюу цэвэр шилжүүлэг 0.9 их наяд төгрөг болж, ҮНО 33.6 их наяд төгрөг, ҮНЭО 34.5 их наяд төгрөг боллоо. ҮНО, оны үнээр өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар, ҮНЭО 22.9 хувиар тус тус өслөө.

ХҮСНЭГТ 10. ДНБ, ҮНО, ҮНЭО, оны үнээр

Бүрэлдэхүүн	2022	2023	2024*	Өөрчлөлт	
	I-VI	I-VI	I-VI	дүн	хувь
	тэрбум төгрөг				
Дотоодын нийт бүтээгдэхүүн	23 352.6	30 979.6	37 419.7	6 440.1	20.8
Гадаад эдийн засгаас орж ирсэн анхдагч орлого, цэвэр	-1 718.6	-3 562.2	-3 816.4	- 254.3	-
Ажиллагчдын цалин, цэвэр хүлээн авсан цалин (+)	326.7	390.0	527.2	137.2	35.2
төлсөн цалин (-)	404.8	545.2	614.4	69.2	12.7
Хөрөнгө оруулалтын орлого, цэвэр	78.1	155.2	87.2	- 68.0	-43.8
Хөрөнгө оруулалтын орлого (+)	-2 045.3	-3 952.2	-4 343.6	- 391.4	-
Хөрөнгө оруулалтын зардал (-)	69.4	205.2	290.3	85.2	41.5
Үндэсний нийт орлого	21 633.9	27 417.4	33 603.2	6 185.8	22.6
Гадаад эдийн засгаас орж ирсэн хоёрдогч орлого, цэвэр	591.9	625.5	857.7	232.1	37.1
Харьяат бусаас хүлээн авсан (+)	700.2	755.9	1 004.5	248.6	32.9
Харьяат бусад төлсөн (-)	108.4	130.4	146.9	16.5	12.7
Үндэсний нийт эзэмшлийн орлого	22 225.8	28 042.9	34 460.9	6 418.0	22.9

ЗУРАГ 12. АНХДАГЧ ОРЛОГО, ҮНО, ДНБ-ИЙ ХАРЬЦАА



ҮНО болон ДНБ-ий харьцааг хувиар илэрхийлбэл, 2023 оны эхний хагас жилд ҮНО/ДНБ-ий харьцаа 88.5, 2024 оны эхний хагас жилд 89.8 болж өслөө.

Анхдагч цэвэр орлогын ДНБ-д эзлэх хувь 2024 оны эхний хагас жилд -10.2 болов. ДНБ-ий 2.4 хувьтай тэнцэх хэмжээний анхдагч орлогыг 2024 оны эхний хагас жилд бусад улсаас хүлээн авсан бол 12.6 хувьтай тэнцэх анхдагч орлогыг бусад улсад шилжүүлсэн байна.

ХҮСНЭГТ 11. ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний хагас жилд

Үзүүлэлтүүд	2022	2023	2024*	Өөрчлөлт	
	I-VI	I-VI	I-VI	дүн	хувь
	тэрбум төгрөг				
ДНБ, ҮНО					
ДНБ, оны үнээр	23 352.6	30 979.6	37 419.7	6 440.1	20.8
ДНБ, 2015 оны үнээр	12 807.9	13 660.8	14 419.1	758.3	5.6
ДНБ-ий бодит өсөлт, бууралт, %	2.0	6.7	5.6		
Уул уурхайн салбарын оролцоо	- 4.0	3.9	1.8		
Уул уурхайн бус салбарын оролцоо	4.2	2.4	1.4		
Бүтээгдэхүүний цэвэр татварын оролцоо	1.7	0.4	2.3		
Үндэсний нийт орлого, оны үнээр	21 633.9	27 417.4	33 603.2	6 185.8	22.6
Үндэсний эзэмшлийн орлого, оны үнээр	22 225.8	28 042.9	34 460.9	6 418.0	22.9
ХҮИ өмнөх оны мөн үеэс, %	16.9	10.6	5.1		
Санхүүгийн сектор					
Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж	4 401.5	7 235.1	9 755.8	2 520.8	34.8
Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээл	8 191.9	9 033.8	12 911.3	3 877.5	42.9
Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-3 790.4	-1 798.8	-3 155.5		-
Мөнгөний сектор					
Мөнгө М1, сарын эцэст	6 067.1	8 282.0	11 804.3	3 522.3	42.5
Мөнгө М2, сарын эцэст	27 635.5	31 448.2	41 420.3	9 972.1	31.7
Зээлийн өрийн үлдэгдэл, сарын эцэст	23 471.3	25 575.5	33 486.5	7 910.9	30.9
Хадгаламж, сарын эцэст	18 336.0	19 574.5	24 188.4	4 613.9	23.6
Гадаад худалдаа					
Барааны нийт эргэлт	9 257.1	11 827.0	13 264.6	1 437.7	12.2
Экспорт	5 309.1	7 553.6	7 886.2	332.7	4.4
Импорт	3 948.0	4 273.4	5 378.4	1 105.0	25.9
Тэнцэл	1 361.0	3 280.1	2 507.8	- 772.4	-23.5
Гадаад худалдааны тэнцлийн ДНБ-д эзлэх %	5.8	10.6	6.7		
Бодит сектор, оны үнээр					
АҮ-ийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл	8 544.7	13 373.1	15 571.3	2 198.3	16.4
Уул уурхай	5 496.8	9 249.5	11 198.0	1 948.5	21.1
Уул уурхайн бус	3 047.9	4 123.6	4 373.3	249.8	6.1
Барилга угсралт, их засварын ажил	2 507.3	2 976.3	3 697.5	721.2	24.2
Дотоод худалдааны борлуулалт	20 823.4	26 615.5	31 055.1	4 439.7	16.7
Мэдээлэл, шуудан, холбооны орлого	854.7	985.9	1 169.5	183.6	18.6
Тээврийн нийт орлого	1 588.2	2 792.2	3 485.8	693.6	24.8
Шилжүүлсэн сая т.км	8 293.1	13 492.6	14 501.0	1 008.3	7.5
Авто тээвэр	1 234.7	3 677.9	4 171.3	493.4	13.4
Төмөр замын тээвэр	6 982.0	9 659.5	10 122.6	463.1	4.8
Агаарын тээвэр	76.4	155.2	207.1	51.9	33.4
Тээсэн ачаа, мян.т	28 316.7	49 266.0	55 642.9	6 376.9	12.9
Авто тээвэр	9 202.0	29 279.6	39 199.0	9 919.4	33.9
Төмөр замын тээвэр	5 793.9	6 044.1	6 399.7	355.6	5.9
Агаарын тээвэр	6.5	4.1	4.6	0.5	12.8
Зочид буудлын салбарын нийт орлого	159.5	218.6	244.2	25.6	11.7
Нийтийн хоолны салбарын нийт орлого	591.6	679.6	816.3	136.8	20.1
Нүүрс:					
Олборлолт, мян.т	10 418.1	35 053.4	47 648.6	12 595.2	35.9
Экспорт, мян.т	8 081.4	29 519.9	40 619.8	11 099.9	37.6